

1985 оны 1282-р захирагчийн хураалт

БНМАУ-ЫН САЙД НАРЫН ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ
АВТО ЗАМЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ,
УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

1988 оны 6 дугаар
сарын 13 ны өдөр

Дугаар 106, /156

Улаанбаатар
хот

Авто замын засвар ашиглалтын
дистанц байгуулах тухай

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх Авто замын ерөнхий газар, хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1. Багануурын районы нутаг дэвсгэрийн хатуу хучилттай замын ашиглалт хариуцсан авто замын засвар ашиглалтын дистанцыг 1988 оны 7 дугаар сарын 1-нээс эхлэн байгуулж ажиллуулахыг Багануурын районы АДХ-ын гүйцэтгэх захиргаа /н. Дашдаваа/, Хот тохижуулах трест /н. Доржпүрэв/-д зөвшөөрсүгэй.

2. Дистанцад шаардлагатай машин техникийг хөрөнгө оруулалтаар авч хангахыг Хотын төлөвлөгөөний комисс /н. Батбаяр/, Хот тохижуулах газар /н. Баатар/-т даалгасугай.

3. Багануурын районы зам ашиглалтын дистанцын орон тоо, цалингийн фондыг нормативын дагуу хянан баталж, зардлыг хотын замын засвар арчлалтанд олгогдсон замын хураамжийн хөрөнгөнөөс санхүүжүүлж байхыг санхүүгийн хэлтэс /н. Гонгор/, Багануурын районы АДХ-ын гүйцэтгэх захиргаа /н. Дашдаваа/-нд даалгасугай.

АВТО ЗАМЫН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА

Г. ЖИГЛИЙ

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ
ДАРГА

С. МӨНХМАРТАЛ